

## БИЧЛЭГИЙН ТӨРӨЛ, ЗҮЙЛИЙН ОНОЛЫН ЗАРИМ АСУУДАЛД

М. Зулькафиль\*, Н. Болормаа\*\*

\* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн эрхлэгч, шинжлэх ухааны доктор (ScD), МУИС-ийн тэргүүлэх профессор  
\*\* МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхмийн докторант, магистр

**Түлхүүр үг:** чөлөөт хэвлэл, бичлэгийн төрөл зүйл, агуулга ба хэлбэр, ур чадвар, арга.

Сэтгүүл зүйн онол, практикт ихээхэн маргаантай, хараахан нэг мөр шийдэгдээгүй цөөнгүй асуудал байгаагийн нэг бол бичлэгийн төрөл, зүйлийн тухай асуудал юм. Манай оронд чөлөөт сэтгүүл зүйн эх суурь тавигдаж, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн бие даасан байдал ихээхэн өргөжсөн нь сэтгүүлчдийн уран бүтээлийн эрх чөлөө бодит үзэгдэл болж, энэ нь нийтлэл, нэвтрүүлгийн агуулга төдийгүй хэлбэр, төрөл, зүйл, бичлэгийн арга барилд томоохон өөрчлөлт гарахад нөлөөлсөн билээ. Нөгөө талаар сэтгүүлч, судлаачдын бичлэгийн төрөл, зүйл хэмээх ойлголт тод хандах хандлага нь ч тодорхой хэмжээгээр өөрчлөгдсөн нь ажиглагддаг. Үүнийг сонин хэвлэлд нийтлэгдэж буй материалуудын бичлэгийн төрөл, зүйлийг тодорхойлоход нарийн төвөгтэй, нэгдэн нийлсэн холимог шинжтэй болж байгаагаар тайлбарлаж болно.

Өнөөдөр бичлэгийн төрөл, зүйлийн талаар сэтгүүлчдийн дунд хэд

хэдэн төсөөлөл, ойлголт бий болсон нь тод мэдрэгддэг. Тэдний нэг хэсэг нь бичлэгийн төрөл, зүйл буюу нийтлэл, нэвтрүүлгийн хэлбэр, яаж бичсэн нь чухал биш, харин агуулга нь чухал учраас үүнд л гол анхаарлаа хандуулах шаардлагатай гэж үздэг байна. Нөгөө хэсэг нь бичлэгийн төрөл, зүйлийг баримталж бичсэн байхад илүүдэхгүй, үгүй байхад дутах юмгүй гэсэн бодолтой байдаг. Гурав дахь хэсэг нь бичлэгийн төрөл, зүйл сэтгүүлчийн ур чадварын шалгуур учраас тодорхой нэг бичлэгийн төрөл, зүйлийн шаардлагад нийцүүлж, олон янзын төрөл хэлбэрээр бичих шаардлагатай гэж үздэг. Өнгөцхөн хандвал аль нь ч үнэн юм шиг сэтгэгдэл төрүүлнэ. Гэхдээ бичлэгийн төрөл, зүйл хэмээх ойлголтыг сэтгүүлчийн ур чадвар, нийтлэл, нэвтрүүлгийн агуулга хэлбэрийн нэгдэлтэй салшгүй холбоотой сэтгүүл зүйн онол, практик, арга зүйн үндсэн категориудын нэг гэж ойлговол дээрх хандлага, төсөөлөлд ихээхэн шүүмжлэлтэй хандах шаардлага тулгарч байна. Бичлэгийн төрөл, зүйл бол нийтлэл эсвэл нэвтрүүлгийн хэлбэр төдий зүйл биш

юм. Ингэж ойлгох явдал сэтгүүл зүйн практикт маш өргөн дэлгэрсэн нь өнөөдөр манай сонин хэвлэлийн нийтлэл, радио телевизийн нэвтрүүлгийн бичлэгийн арга барил, хэлбэр нэг хэв загварт баригдаж, бичлэгийн цөөхөн хэдэн төрлийн хүрээнд эргэлдэж, сэтгүүл зүйн мэргэжлийн төвшин дэндүү доошилоход нөлөөлж байна. Ийм хандлагын улмаас өнөөдөр манай тогтмол хэвлэл ярилцлага нэртэй асуулт хариултын эвлүүлэг, эргэцүүлэл нэртэй хувь хүний үзэл бодлын тухай тэмдэглэл, мэдээ гэсэн 3-4 бичлэгийн зүйлийн хүрээнд эргэлддэг болсон нь нууц биш юм. Нөгөө талаар төрөл, зүйлийг тодорхойлж бичсэн нийтлэл, нэвтрүүлгийн чанар муу, тухайн төрөл зүйлд тавигдах шаардлагыг огт хангаагүй байгаа нь ажиглагддаг. Мөн хэвлэл мэдээллийн зарим ажилтан энэ асуудалд ихээхэн хайнга хандсаны улмаас бичлэгийн ур чадвар, хэл найруулга, агуулга хэлбэрийн нэгдэл эрс муудсан бөгөөд үүнд хэвлэл мэдээллийн удирдах хүмүүс ч буруутай гэдэг нь тодорхой юм. Өөрөөр хэлбэл, хэвлэл мэдээллийн газраас сэтгүүлчдэд тавих шаардлага, хяналт, редакторлах үйл ажиллагаа эрс суларсан гэсэн үг. Доктор Л.Түдэвийн хэлсэнчилэн "Сэтгүүлчийн ур чадварыг хазаарлаж байгаа нэг ноцтой дутагдал нь сонин бичлэгийн төрөл зүйл бүрийг ажиглаж чадахгүйгээс мэдээ, сурвалжлагаас

хэтрэхгүй, өрөөсгөл байдал нийтлэг шинжтэй болжээ. Төрөл зүйлийн ядуурал нь үгийн сангийн ядууралтай адилхан сэтгүүлчийг бүтээгдэхүүний гологдолд хүргэх их хортой зүйл мөн. Сонин сэтгүүлийн газрууд ч бичлэг, нийтлэлийн төрөл зүйлийг олшруулахад төдий л санаачлага гаргахгүй байна ... Бичлэгийн төрөл зүйл цөөн учраас сэтгүүлчид уран чадвараар өсөхгүй байна"<sup>1</sup>.

«

*Өнөөдөр манай тогтмол хэвлэл  
ярилцлага нэртэй асуулт  
хариултын эвлүүлэг, эргэцүүлэл  
нэртэй хувь хүний үзэл бодлын  
тухай тэмдэглэл, мэдээ гэсэн 3-4  
бичлэжээгийн зүйлийн хүрээнд  
эргэлддэг болсон нь нууц биш юм*

»

Энэ бүхэн нь өнөөдөр олон түмний итгэлийг алдах, ирээдүйн сэтгүүлчид болон сэтгүүл зүйг сонирхогчид, идэвхтэн бичигчдэд буруу зөрүү ойлголт төрүүлэх, сэтгүүл зүйн нэр хүндийг бүхэлд нь бууруулахад нөлөөлж байна. Хэдийгээр энэ бүхэн

нь бичлэгийн төрөл, зүйлтэй шууд холбоотой биш боловч сэтгүүлчийн ур чадварын шалгуур, агуулга хэлбэрийн нэгдлийн илэрхийлэл болохын хувьд чухал нөлөөтэй гэдэг нь ойлгомжтой.

Бичлэгийн төрөл, зүйл бол түүхэн хөгжлийн явцад төлөвшиж бий болсон бүтээлийн хэв маяг бөгөөд хэн нэгэн сэтгүүлч, судлаачийн санаа бодол, хүсэл зорогоос үл хамааран объектив оршиж байдаг онцлогтой юм. ОНМХ-ийн нийт нийтлэл, нэвтрүүлгийг тэдний маш олон шинж тэмдгийг харгалзан бичлэгийн төрөл, зүйлүүдэд хуваадаг. Учир нь аль ч бүтээлд ямар нэгэн бичлэгийн төрөлд оруулах үндэслэл, тодорхой шинж тэмдэг, өөрийн гэсэн онцлог, товчоор хэлбэл, бичлэгийн

төрөл, зүйлд хуваарилах зарчим байдаг. Тийм шинж тэмдгүүд санамсаргүй, тохиолдлын шинжтэй, эсвэл зохиогчийн бүтээлч эрэл хайгуул, урьдчилж тодорхойлсон зорилгын үр дүнд бий болдог. Аль ч тохиолдолд нийтлэл, нэвтрүүлгийн тодорхой нэг хэлбэр үүсдэг нь жам ёсны үзэгдэл юм. Тийм эх бичвэрүүдийг ижил төстэй шинж тэмдгүүдийг харгалзан хэсэг, бүлгүүдэд хуваарилж болдог. Ингэж бүлэглэх нь тодорхой нэг үндэслэлийн дагуу янз бүрийн төвшинд явагддаг бөгөөд үүнийг хамгийн чухал гэж үзсэн үндэслэл, шалтгаан, хүчин зүйлийг харгалзан судлаачид, эсвэл практик ажилтнууд хийдгийг бид мэднэ. Чухам энэ үндэслэл янз бүрийн төсөөлөл, маргааны шалтгаан болдог. Хамгийн гол нь ямар нэг тогтвортой бүлэглэлд хамруулж болох нийтлэлийн нийтлэг шинжид үндэслэгдсэн ангилал чухал гэдэг нь ойлгомжтой. Зөвхөн үүний дараа л бид бичлэгийн төрөл, зүйлийн шинж чанар, төрөл, зүйл, хэлбэрийн тухай ярих боломжтой юм.

**Н**өгөө талаар бичлэгийн төрөл, зүйл бол нийтлэл, нэвтрүүлгийн тодорхой нэг хэлбэр учраас агуулгагүй оршин тогтох боломжгүй гэдэг нь ойлгомжтой. Энэ бол аксиом. Аксиомд баталгаа хэрэггүй гэдгийг бүгд мэднэ. Тэгвэл агуулгагүй нийтлэл, нэвтрүүлэг оршихгүйн нэгэн адил хэлбэргүй нийтлэл, нэвтрүүлэг оршихгүй. Үүнээс гарах логик дүгнэлт ганцхан: нийтлэлийн хэлбэр байгаа цагт бичлэгийн төрөл, зүйл хэмээх ойлголт байх болно. Харин түүний ямар шалгуур, шинж тэмдгийг харгалзан ямар бичлэгийн төрөлд оруулж, яаж нэрлэх нь өөр асуудал юм.

Бичлэгийн төрөл хэвлэл мэдээллийн ажилтнуудын хоорондох мэргэжлийн харилцаанд ч чухал ач холбогдолтой. Сонины эрхлэгч тодорхой нэг хүний тухай материал бэлтгэхийг даалгасан нөхцөлд чухам ямар бүтээл шаардах нь тодорхой бус, сэтгүүлчийн ажилд хүндрэл учруулж болох талтай. Харин тийм хүний тухай хөрөг найруулал бич гэвэл эрхлэгч юу хүсэж байгаа нь маш тодорхой, сэтгүүлч зорилгоо ч амархан төсөөлж болно. Өөр нэг тэмдэглэх зүйл бол бидний 2003 онд "Чөлөөт хэвлэлийн төлөвшил, олон нийтийн санаа бодол" төслийн хүрээнд явуулсан судалгаанд хамрагдсан хот, хөдөөний 700 хүний ердөө 41 нь буюу 5,9 хувь нь бичлэгийн төрөл, зүйл чухал биш гэж үзжээ. Мөн 19,1 хувь нь аян замын тэмдэглэлийг, 10,6 хувь нь тэмдэглэлийг, найрууллыг 11,1 хувь нь, эссе 7,3 хувь нь уншихыг хүсдэгээ илэрхийлсэн<sup>2</sup> нь 90-ээд оны эхэн үед сонины бичлэгийн төрөл, зүйл бол коммунист сэтгүүл зүйд хүчээр оруулж ирсэн зүйл, мэдээллийг ямар хэлбэрээр хүргэсэн нь бус, агуулга нь чухал, иймээс санаагаа гаргаж л байвал төрөл зүйл хамаагүй гэж ярьж, бичиж байсан нь өнөөдөр эсрэгээр эргэснийг харуулж байна.

"Бичлэгийн төрөл, зүйл бол улс төрийн сонины концерт мөн" гэсэн суут сэтгэгчийн үг бий. Үүнийг ухаж ойлговол олон санаа агуулагдаж буй нь илэрхий. Энэ бол мэдээллийг олон янзын өнгө аяс, арга хэлбэрээр, сонирхолтой хүргэх шаардлагатай гэсэн үг юм. Өнөөдөр энэ шаардлага ихээхэн зөрчигдөж, бүх нийтлэл бичлэгийн нэг хэв загварт баригдаж, бичлэгийн төрөл зүйлийн хомсдолд орсон гэж хэлэх бүрэн үндэстэй.

Үүнийг манай нийгэм-улс төрийн өдөр тутмын сониноос эхлээд "шар сонин" хүртлэх ямар ч тогтмол хэвлэлээс амархан ажиглаж болно. Энэ бол сэтгүүлч уран бүтээлчдийн эрэл хайгуул, идэвх санаачлага, бүтээлч хандлага сул байгаагийн илрэл бөгөөд сэтгүүл зүйн мэргэжлийн төвшин, ур чадварт нөлөөлж буй хамгийн гол хүчин зүйл мөн. Ур чадвар бол чанарын хэмжүүр, уран бүтээлийн шалгуур байдаг. Ур чадварын илэрхийлэл болох бичлэгийн төрөл, зүйлийн ядууралд орсон нь манай сэтгүүлчид бичлэгийн бүтээлч арга барил, шинэлэг хандлагыг эзэмшээгүй байгаагийн илрэл юм.

**А**ливаа эх бичвэрийг ямар төрөл, зүйлд хамааруулахыг шийдвэрлэдэг онцлог шинжүүдийг яаж тодорхойлох вэ? Энэ бол юуны өмнө сэтгүүл зүйн судлагдахууны өвөрмөц онцлог, зохиогчийн бодит байдлыг тусгаж буй арга барилаар тодорхойлогдоно. Сэтгүүл зүйд нийтлэл, нэвтрүүлгийн судлагдахуун нь нийгмийн, эсвэл байгалийн цаг үеийн үзэгдэл, үйл явдал, нөхцөл байдал, үйл явцын янз бүрийн илрэлүүд болдог бөгөөд энэ нь нийгэмд онол, практикийн хувьд чухал ач холбогдолтой тулгамдсан асуудлууд, зөрчлүүдийг бий болгодог. Мөн хүн, түүний амьдрал ч судлагдахуун болох онцлогтой. Харин бодит байдлыг тусгах арга барилын үүрэг, ач холбогдол нь сэтгүүлчийн эх бичвэрийн бичлэгийн төрлийг тодорхойлдог шинж чанаруудыг илэрхийлэхэд материалын тусгах объектээс илүү чухал үүрэг гүйцэтгэх болно.

Сэтгүүл зүйд бодит байдлыг тусгах баримтыг мэдээлэх, задлан

шинжлэх, уран сайхнаар илэрхийлэх гэсэн үндсэн гурван арга байдаг. Тэд субъектын объектыг танин мэдэх, агуулгад нь нэвтрэх тодорхой төвшинүүдийг бий болгодог онцлогтой юм. Нэг дэх ба хоёр дахь арга нэг нь нөгөөгөөс тусгаж байгаа зүйлийн мөн чанарт нэвтрэх төвшингөөр ялгаатай. Нэг дэх арга юуны өмнө үзэгдлийн гадаад шинж чанарыг тусгах, баримтын тухай товч мэдээлэл олж авах буюу хэзээ, хаана, юу болсон тухай мэдээлэл цуглуулахыг зорилго болгодог. Энэ нь мэдээллийн шуурхай байдлыг хангах, хүлээн авагчдад цаг үеийн мэдээллийг богино хугацаанд хүргэхэд тусалдаг. Тэгвэл хоёр дахь арга үзэгдлийн мөн чанарт нэвтрэх, тусгаж буй зүйлийн далд харилцаа холбоог илрүүлэхэд чиглэгддэг бөгөөд сэтгүүлч харьцангуй өргөн хүрээний асуудлуудад хариулт өгдөг. Энэ тохиолдолд зохиогч үйл явдал, үзэгдлийн хөгжлийн чиг хандлага, нөхцөл байдал, онцлог шинж, шалтгааныг илрүүлэх, оролцож буй нийгмийн хүчнүүдийн хүсэл сонирхол, зорилго, хэрэгцээ шаардлагыг судлах, тэдний хооронд үүссэн зөрчлийг тайлбарлах, янз бүрийн үзэгдлүүдийн ач холбогдлыг үнэлэх, аливаа үзэл бодол, санал зөвлөмж, шинэ санал, санаачлагын үндэслэлийг тайлбарлах замаар нийгмийн хөгжлийн үр ашигтай замыг сонгохтой холбоотой асуудлуудад хандахыг зорилго болгодог.

Бодит байдлыг дүрслэн харуулах, уран сайхны элементүүдийн тусламжтайгаар илэрхийлэх арга бол үзэгдлийн зөвхөн гадаад шинж тэмдэгийг тусгах, дотоод мөн чанарт нэвтрэх төдийгүй таньж мэдсэн зүйлийг уран сайхны аргаар илэрхийлэх зорилго тавьдгаа-

раа онцлогтой юм. Заримдаа ийм хандлага хэв шинжит дүр бүтээх төвшинд хүргэдэг учраас сэтгүүл зүйг уран зохиолтой ойртуулдаг тал бий. Ийм аргаар сэтгүүл зүй тусгаж буй объектыг хүлээн авагчдад оновчтой хүргэж, бас сэтгэлийн хөдөлгөөний тусламжтайгаар хүлээн авах боломжийг бүрдүүлдэг.

Бодит байдлыг тусгах аливаа аргын өвөрмөц онцлог нь янз бүрийн төвшинд харилцан уялдаа холбоонд оршдог зорилгуудыг хэрэгжүүлэх, тодорхой зорилтуудыг шийдвэрлэх өвөрмөц зам болдог. Тийм зорилгуудын зарим нь тодорхойлогч шинжийг агуулж, тухайн тогтмол хэвлэлийн үйл ажиллагаанд гол үүргийг гүйцэтгэдэг. Тийм үүрэг

маш олон байж болно. Зарим хэвлэл арилжааны зорилгыг тэргүүн зэрэгт тавьдаг учраас юуны өмнө хүмүүсийг хөгжөөх, цэнгээхэд чиглэгдсэн мэдээлэлд түлхүү анхаарч, хүмүүсийн хувийн хэрэгцээг дээд зэргээр хангахад чиглэгдсэн сэдвийг сонгон авч, тэр хэрэгцээ шаардлагын үүднээс боловсруулахыг хичээдэг. Ийм зарчмыг гол төлөв "шар хэвлэлүүд" баримталдаг бөгөөд тэдэнд хүлээн авагчдын болон нийгмийн эрх ашгийг хөндсөн улс төр, нийгэм-эдийн засгийн тулгамдсан асуудлууд чухал биш юм.

Зарим тогтмол хэвлэл хүлээн авагчдад улс төрийн, шашны гэх мэт суртал нэвтрүүлгийн нөлөө үзүүлэхийг

зорилго болгодог бол гурав дахь нь олон нийтийн язгуур эрх ашиг, хэрэгцээ сонирхолтой холбоотой үнэн бодитой мэдээллээр хангах, тэднийг соён гэгээрүүлэх чухал хэрэгсэл болох зорилтыг эрхэмлэн үнэн бодитой мэдээллээр бүрэн хангахыг чухалчилдаг байна. Үүний зэрэгцээ нэг тогтмол хэвлэл янз бүрийн зорилтыг нэгэн зэрэг агуулдаг нь түгээмэл байдаг. Энэ тохиолдолд тийм зорилго юуны өмнө нийтлэгдэж

буй материалуудын шинж чанарт нөлөөлдөг. Сэтгүүл зүйн дээр дурдсан зорилго, үүргүүд сэтгүүлчдийн бодит байдлыг таньж мэдэх арга барилтай холбоотой "хоёрдугаар эгнээ"-ний тодорхой зорилтуудыг буюу уран бүтээлийн үүргүүдийг өөртөө агуулдаг. Үүнд дараах үүр-

«

*Зарим хэвлэл арилжааны зорилгыг тэргүүн зэрэгт тавьдаг учраас юуны өмнө хүмүүсийг хөгжөөх, цэнгээхэд чиглэгдсэн мэдээлэлд түлхүү анхаарч, хүмүүсийн хувийн хэрэгцээг дээд зэргээр хангахад чиглэгдсэн сэдвийг сонгон авч, тэр хэрэгцээ шаардлагын үүднээс боловсруулахыг хичээдэг.*

»

гүүд багтдаг. Үүнд:

- тусгаж буй үзэгдлийн мэдээллийн тодорхой "загвар"-ыг бүтээх (түүний тусгал болох),

- учир шалтгааны харилцаа холбоог тогтоох,

- үзэгдлийн ач холбогдлыг илрүүлэх (үнэлэлт өгөх),

- судалж буй үзэгдлийн ирээдүйн төлөв байдлыг тодорхойлох (таамаглал дэвшүүлэх),

- судалж буй үзэгдэлтэй холбоотой үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөг томьёолох зэрэг болно.

Энэхүү уран бүтээлийн зорилтуудыг ямар ч тогтмол хэвлэлд нийтлэгдэх аливаа эх бичвэрийг бүтээхэд хэрэг-

жүүлэх шаардлагатай юм. Учир нь түүнийг практикт хэрэгжүүлэх үйл явц бидний дээр дурдсан сэтгүүл зүйн үүргүүдийг хэрэгжүүлэх боломжийг нээж өгдөг. Уран бүтээлийн зорилтууд сэтгүүлчийн хувьд нийгмийн янз бүрийн үзэгдлүүдийг судлах, тэдний мөн чанарыг илрүүлэн харуулах, шалтгааныг тодруулах, үзэгдлүүдийн хөгжлийг таамаглах, ач холбогдлыг тайлбарлах, мөн янз бүрийн зорилтуудыг шийдвэрлэх шинэлэг арга барил, санаачлагыг судлах, түүнийг шийдвэрлэх хөтөлбөр, удирдамжийг боловсруулах, аливаа зорилгод хүрэхэд үр ашиггүй, шаардлагагүй арга замыг сонгохоос урьдчилан сэргийлэх, маргаантай үзэл бодлын үндэслэлийг гаргахад тавигдах шаардлага болдог онцлогтой юм. Мөн тусгаж буй үзэгдлийг нэгтгэн дүгнэх, түүний дүр төрхийг уран сайхны аргаар илэрхийлэх замаар өөрийнхөө бодит ертөнцөд хандах хандлагыг тодорхойлох шаардлагыг бий болгодог. Сэтгүүлчид энэ зорилтуудыг шийдвэрлэх замаар нийгмийн амьдралын бүх талыг хамарсан шуурхай, задлан шинжилсэн, уран сайхны аргаар илэрхийлсэн мэдээллийг бүтээдэг, мөн хүлээн авагчдад нийгмийн чиг баримжааг тодорхойлох, түүний тусламжтайгаар өөрийнхөө үйл ажиллагааг зохицуулах, шийдвэр гаргах, мэдлэгийн хүрээг өргөтгөх, алжаал тайлахад шаардлагатай мэдээллийг өгдөг. Сэтгүүлч уран бүтээлийн зорилгыг хэрэгжүүлэх явцад бодит байдлыг танин мэдэх янз бүрийн аргыг хэрэглэдэг. Ийм аргуудыг туршилтын буюу баримтат, онолын болон уран сайхны аргууд гэсэн гурван том бүлэгт хувааж болно. Нэгдүгээр бүлэгт мэдээлэл, баримт цуглуулахад чиглэгдсэн

ажиглалт, яриа, ярилцлага, баримт бичгүүдийг боловсруулах зэрэг арга багтдаг бол хоёрдугаар бүлэгт танин мэдэхүйн ерөнхий онолын (задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, индукци, дедукци, логикийн, харьцуулан судлах, түүхчилэн судлах, таамаглал дэвшүүлэх г.м.) болон дүрслэн харуулах, шалтгаан-үр дагаврын шинжилгээ хийх, үнэлэлт өгөх, таамаглал дэвшүүлэх, программчилах зэрэг ерөнхий онолын аргуудад тулгуурласан цуглуулсан материалуудыг боловсруулах мэргэжлийн тусгай аргууд ордог. Судалгааны онолын аргуудыг ашиглах нь аналитик сэтгүүл зүйг ямар нэг хэмжээгээр шинжлэх ухааны танин мэдэхүйн судалгаанд ойртуулдаг боловч олон шинж чанараар түүнээс эрс ялгаатай юм.

**Г**уравдугаар хэсгийг адилтгах, бүтээлчээр ургуулан бодох, хүншүүлэх, багасгах, хэтрүүлэх, харьцуулах, тусгай дүгнэлтийг ерөнхийгөөр, ерөнхий дүгнэлтийг тусгайгаар солих зэрэг аргад тулгуурласан уран сайхны аргууд бүрдүүлдэг байна.

Энэхүү орчин үеийн сэтгүүл зүйн судлагдахуун, үүрэг, аргуудын тодорхойлолт, онцлог шинжээс шалтгаалан өдгөө тогтмол хэвлэлд нийтлэгдэж буй бичлэгийн төрөл, зүйлүүдийг тодруулах, боловсруулах, эргэж харахад зайлшгүй анхаарч үзүүштэй дараах дүгнэлтүүдийг хийж болох байна. Үүнд:

1. Хэрэв сэтгүүлч хүлээн авагчдыг мэдээллээр шуурхай хангах шаардлагатай гэж үзвэл энэ нь юуны өмнө тэдний хамгийн гол, цаг үеийн хэрэгцээ шаардлагатай холбоотой чухал үйл явдал, үзэгдлүүдэд чиглэгдэх ёстой бөгөөд хүлээн авагчдад бодит байдлын дүр зургийг дээд зэргээр үнэн зөв, маш

тодорхой тусгаж авахад туслах шаардлагатай юм. Хэрэв бодит байдлыг нэлээд гүнзгий судлах, цаг үеийн чухал асуудлуудыг, орчин үеийн үйл явдал, нөхцөл байдал, үйл явцын мөн чанар, ач холбогдлыг тайлбарлан таниулах, ойлгуулах, тодруулах шаардлагатай бол сэтгүүлч судалж буй асуудал, үйл явдал, үйл явц, нөхцөл байдлыг бусад үзэгдлүүдтэй харилцан уялдаа холбоонд авч үзээд нийгмийн амьдралын хөгжлийн хандлага, зүй тогтол, үзэгдлүүдтэй харьцуулан үзүүлэх ёстой юм. Хэрэв сэтгүүлч бодит байдлыг уран сайхны аргаар дүрслэн харуулах бол бодит байдлын талаарх өөрийн төсөөллийг уран сайхны хэв шинжийн тусламжтайгаар өгөх бөгөөд ингэхдээ хэв шинжит дүрээр дамжуулан өгч байгаа бодит байдлыг ямар ч өөрчлөлтгүйгээр байгаагаар нь өгөх зорилго тавьдаг. Чухам энэ шинж нь уран зохиолд байдаг ургуулан бодох, уран сэтгэмжид үндэслэгдсэн хэв шинжит дүрээс ялгагдах гол онцлог болно.

**2.** Нийтлэл, нэвтрүүлэгт тусгасан нийгмийн тулгамдсан асуудлуудыг ойлгохын тулд хөндөж буй үйл явдал, үзэгдлүүд болон тэдний практик үр дагавар, бодит амьдрал дахь өөрчлөлтүүдийн хоорондох хамгийн үр ашигтай уялдаа холбоог олж харах нь чухал байдаг. Тиймээс сэтгүүлчид "үндэслэл-үр дүн" (учир шалтгааны хамаарал), "хэрэгсэл-зорилго" (үр дүнгийн хамаарал), "тогтворгүй харилцан нөлөөлөл-бодит зөрчил" (тогтворгүй харилцан нөлөөллийн тодорхой төрөл) гэсэн харилцааг чиг баримжаа болгодог. Энэ бүхнээс шалтгаалж судалж буй үзэгдлүүдийн хоорондох харилцаа холбооны талаарх

санаа бодол шинжлэлт болон нийтлэл-уран сайхны бичлэгийн төрөлд хамаарах ихэнх нийтлэлийн гол үндэс суурийг бүрдүүлдэг.

3. Сэтгүүл зүйн тодорхой бүтээлийн агуулга, хэлбэр болгон өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой. Хэрэв мэдээллийн бичлэгийн төрлийн материалуудад тодорхой нэг баримтыг тусгахыг чухалчилдаг бол шинжлэлт бичлэгийн төрөлд юуны өмнө баримтын нийлбэр цогцод үндэслэгдсэн зохиогчийн санаа бодол болон энэ бодлоос төрсөн сэтгэлийн хөдөлгөөн тэргүүн байранд тавигддаг. Тэгвэл нийтлэл-уран сайхны бичлэгийн төрлүүдийн үндсэн шинж нь тусгаж буй үйл явдал, үзэгдлийг уран сайхны аргаар нэгтгэн дүгнэж, түүний уран дүрслэлийн тусламжтайгаар илэрхийлсэн хэлбэр болдог онцлогтой.

4. Аливаа бичлэгийн төрөл зүйлийг бүтээхэд бодит байдлыг танин мэдэх туршилтын арга, үйлдлүүдийг (ажиглалт, баримт бичгийг боловсруулах, санал асуулга, ярилцлага г.м.), мөн харьцуулах, үнэлэлт өгөх, адилтгах (бодит байдлыг нийгмийн зорилго, хэм хэмжээ, туйлын зорилгуудтай харьцуулах), нарийвчлан дүн шинжилгээ хийх (үзэгдэл, үйл явц, нөхцөл байдлын хамгийн гол шинж чанарыг тодруулах, илрүүлэх), тайлбарлах (шалтгаан, зүй тогтлууд, батлагдаж шалгагдсан санаа бодолтой уялдах харилцаа холбоог илрүүлэх), урьдчилан таамаглах (зүй тогтол, шалтгаан, хүчин зүйлүүд эсвэл танин мэдсэн чиг хандлагаас урган гарсан ирээдүйн үйл явцыг тодруулах), дүгнэлт гаргах (тусгай баримтуудын ижил төстэй шинжүүдийг нэгтгэх, үйл явц дахь нийтлэг шинжүүдийг тогтоох) зэрэг

онолын аргуудыг түгээмэл хэрэглэдэг. Ийм аргуудад олон хүчин зүйл нөлөөлдгийн дотор мэдээллийн эх сурвалжийн тухайн нөхцөл байдлын онцлогийг чиг баримжаа болгосон зохиогчийн санаа бодол, шалтгаан, мөн эх сурвалжийн нийгмийн байр суурь чухал нөлөө үзүүлдэг. Үүнийг сэтгүүлч танин мэдэхүйн бэлэн үр дүн болон үзэгдлийн талаарх тайлбарыг өгөхийн хамт танин мэдэх үйл явцыг

хүлээн авагчдад тод мэдрэгдэх төвшинд тусгаж байгаагаас нь төвөггүй ажиглаж болно. Энэ нь сэтгүүлч амьдралыг хүлээн авагчидтай хамт судалж байгаа мэт сэтгэгдэл төрүүлдэг. Үүнийг сэтгүүлчдийн бүтээл нь ихэнх тохиолдолд ярилцлагын шинжтэй материал байх зорилгоос үл шалт-

гаалан ярилцлагын, ярианы шинжтэй эхлэлтэй байгаагаас нь амархан ажиглаж болно. Зохиогч шууд эсвэл дам хүлээн авагчдад ханддаг, өөрийн санаа бодлыг эсвэл хэн нэгний хэлсэн үг, саналыг тайлбарладаг. Тиймээс ихэнх бичлэгийн төрөл, зүйлд асуулт тавих, түүнд хариулт өгөх, ямар нэгэн үзэл бодолд ашигтай байх үүднээс дүгнэлт хийдэг, эсвэл түүнд эсрэг дүгнэлт гаргадаг зэрэг нь түгээмэл бөгөөд энэ нь "хүлээн авагчид"-тай санал бодол солилцох, "харилцах" нэг ёсны боломж болгодог онцлогтой юм.

Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйлүүдийн онцлогийн талаар тодорхой төсөөлөл, мэдлэг олж авах нь

практикийн болон арга зүйн томоохон ач холбогдолтой. Учир нь сэтгүүлч (ялангуяа туршлага багатай залуу уран бүтээлчид) танин мэдэхүйн аливаа нөхцөлд тухайн сонин хэвлэлийн онцлог, хүлээн авагчдын хэрэгцээ сонирхлыг харгалзан тодорхой нэг төрөл, зүйлийн шаардлагын дагуу эх бичвэр бүтээх чиг баримжаатай, ойлголттой ажиллах боломжийг бүрдүүлдэг. Нөгөө талаар сонины тухайн

дугаарт тусгаж байгаа материалуудыг бичлэгийн янз бүрийн өнгө аяс, арга хэлбэрээр, сонирхолтой байдлаар өгөхөд нөлөөлдөг. Энэ нь хүлээн авагчдын сэтгэл зүйд нөлөөлөх нэг гол хүчин зүйл болдгоороо онцлогтой юм. Бичлэгийн төрөл, зүйлийн талаар зайлшгүй хөн-

«

*Бичлэгийн төрөл, зүйлд асуулт тавих, түүнд хариулт өгөх, ямар нэгэн үзэл бодолд ашигтай байх үүднээс дүгнэлт хийдэг, эсвэл түүнд эсрэг дүгнэлт гаргадаг зэрэг нь түгээмэл бөгөөд энэ нь "хүлээн авагчид"-тай санал бодол солилцох, "харилцах" нэг ёсны боломж болгодог онцлогтой юм.*

»

дөх ёстой өөр нэг асуудал бол түүний ангиллын тухай асуудал юм. Бид олон жилийн турш Зөвлөлтийн (хуучин нэрээр) эрдэмтдийн боловсруулсан үндэслэлийн дагуу бичлэгийн төрлүүдийг мэдээлсэн, задлан шинжилсэн, нийтлэл-уран сайхны гэсэн гурван ангилалд хувааж үздэг концепцийг баримталж ирлээ. Өнөөдөр чөлөөт хэвлэл хэвийн үзэгдэл болж, сэтгүүлчдийн ур чадварт гарсан өөрчлөлтөөс шалтгаалан бичлэгийн төрлүүдийн хоорондох зааг ялгаа бүдгэрч, хоорондоо уусах, нэгдэн нийлэх хандлага хүчтэй нэвтэрч, холимог бичлэгийн төрлүүд голлох болсон. Нөгөө талаар, урьд өмнө бичлэгийн тодорхой нэг төрлийн

ангилалд оруулаагүй ирсэн бичлэгийн олон зүйл байсаар байгаагийн хамт зарим нь улам баяжиж, хэлбэрийн хувьд олон янз болж, зарим бичлэгийн төрөл, зүйл шинээр бий болж байна. Бид бичлэгийн төрөл, зүйлүүдийг ангилахад дээрх зүй тогтлыг зайлшгүй харгалзан үзэх шаардлагатай бөгөөд сонинд нийтлэгдэж буй бүх материалыг тодорхой ангилалд хамааруулах нь зөв юм. Орчин үед Оросын зарим эрдэмтэн бидний урьд нэг бичлэгийн зүйлийн дотоод хэлбэр гэж үзэж байсан мэдээлсэн тайлан, шинжлэлт тайлан зэрэг хэлбэрүүдийг бичлэгийн өөр өөр төрөлд хамруулан үздэг<sup>3</sup> болсон нь анхаарал татаж байна. Сонинд сэтгүүлчдийн бичсэн үндсэн нийтлэлээс гадна хүмүүст нэмэлт мэдээлэл өгөх, алжаал тайлахад туслах зорилго бүхий онигоо, элэглэл, эмгэнэл, рейтинг, өчил, наргиа, социологийн тойм мэдээлэл зэрэг бичлэгийн олон зүйл нийтлэгддэг. Мөн цэвэр утга зохиолын бичлэгийн төрлүүд ч цөөнгүй гардаг. Ийм материалууд сэтгүүл зүйн үндсэн бичлэгийн төрлүүд шиг мэдээлэх, танин мэдүүлэх, хяналтын, харилцааны үүргийг гүйцэтгэхгүй бөгөөд нэмэлт мэдээлэл өгөх замаар зугаацуулах үүргийг түлхүү биелүүлдэг онцлогтой. Тиймээс бид сонины бичлэгийн төрлүүдийг 3 биш, мэдээллийн, шинжлэлт, нийтлэл-уран сайхны, туслах чанарын, утга зохиолын гэж 5 ангилах санал дэвшүүлж байна. Доктор Л.Норовсүрэн 4 дэх хэсгийн бичлэгийн төрлүүдийг бичлэгийн жижиг төрлүүд гэж нэрлэх санал дэвшүүлсэн нь зарим талаараа дэмжиж болох талтай ч мэдээгээс эхлээд жижиг зүйл олон байгааг, мөн энэ хэсэгт багтах зүйлүүдийн дотор сонины багагүй зай талбайг эзэлдэг

томоохон зүйл цөөнгүй байгааг харгалзан бичлэгийн туслах төрлүүд гэж нэрлэх нь зөв юм. Нөгөө талаар дээрх бичлэгийн зүйлүүд сонинд заавал байх албагүй бөгөөд байсан нөхцөлд улам сонирхолтой болгодог, байгаагүй тохиолдолд үндсэн бичлэгийн төрлүүд шиг үгүйлэгдэхгүй. Үүнээс үзэхэд цэвэр туслах чанартай гэдэг нь ойлгомжтой. "Туслах" хэмээх үгийг сонгосны учир ч үүнтэй холбоотой юм.

### Ишлэл

<sup>1</sup> Т ү д э в Л. Сэтгүүлчийн эдийн засаг //Бүтээлийн чуулган. ХҮ боть. УБ., 2002, 283 дахь тал.

<sup>2</sup> Олон нийтийн санал бодол, чөлөөт хэвлэлийн төлөвшил. (Төслийн тайлан). МУИС, 2003. 16 дахь тал.

<sup>3</sup> см. Т е р т ы ч н ы й А. А. Жанры периодической печати. М., 2004, с. 52.

### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. В о р о ш и л о в В. В. 2004. Журналистика. СПб.
2. Г о р о х о в В. М. 1988. Закономерности журналистского творчества. М.
3. З у л ь к а ф и л ь М. 1998. Орчин үеийн Монголын сэтгүүл зүй. УБ.
4. К и м М. Н. 2002. Технология создания журналистского произведения. СПб.
5. Н о р о в с ү р э н Л. 2005. Сонины бичлэгийн төрөл, зүйл. УБ.
6. М е л ь н и к Г. С., Т е п л я ш и н а Н. А. 2004. Основы творческой деятельности журналиста. СПб.
7. П о л е т а е в Э. Э. 2003. Международная журналистика. Алматы.
8. Т е р т ы ч н ы й А. А. 2004. Жанры периодической печати. М.

9. Т ү д э в Л. 2002. Сэтгүүлчийн эдийн засаг //Бүтээлийн чуулган. ХҮ боть. УБ.
10. Чөлөөт хэвлэлийн төлөвшил, олон нийтийн санал бодол (Төслийн тайлан). 2003. УБ.: МУИС.
11. B a r a n S. J., D a v i s D. K. 2000. Mass Communication Theory. N- Y.

### Резюме

Автор в статье рассматривает некоторые теоретические и практические вопросы жанров периодической печати и критически относится к некоторым взглядам практических работников печати о жанрах газеты. Опираясь на свои исследования автор делает вывод о том, что формирование знаний и представлений о

жанровых особенностях журналистики имеет весомую практическую значимость, так как оно дает возможность журналистам осознанно ориентировать себя в той или иной познавательной ситуации на создание вполне конкретного типа текста, в наибольшей мере "приспособленного" для адекватного освещения заинтересованной аудитории и издания явления. Автор исследуя жанровые особенности в постсоциалистической журналистике Монголии отмечает, что всем жанрам свойственно взаимопроникновение и на практике границы между ними часто размыты. На основе этого вывода впервые дает свою классификацию жанров газеты: информационный, аналитический, художественно-публицистический вспомогательный (дополнительный) и художественный (литературный) жанры.